

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

“Эн Ви Си ББСБ” ХХК-д хөрөнгө оруулалтын
үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам”-ын 4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эн Ви Си ББСБ” ХХК-д хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Эн Ви Си ББСБ” ХХК /О.Бадрал/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ